



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 310

Улаанбаатар хот

Г Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Эгийн голын усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 66,518,770.00 (жаран зургаан сая таван зуун арван найман мянга долоон зуун далан) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Эгийн голын усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2024 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Эгийн голын усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал М.Баттулга нь Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.2 дахь заалтыг ханган ажиллаагүй байх тул зохих хариуцлага тооцож, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчиний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ерэн-Өлзийд үүрэг болгосугай.

3.“Эгийн голын усан цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Гүйцэтгэх захирал (М.Баттулга)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2.Булган аймгийн Бугат сумын нутаг дэвсгэрт байрлах усан цахилгаан станцын авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын төлөвлөсөн газрын зарим хэсэг нь цэргийн анги, аж ахуйн нэгжийн тариалангийн талбай, “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын хайгуулын талбайн газартай тус тус давхацсан хэмжээг тогтоон, давхардлыг арилгаж, данс бүртгэлд запруулах арга хэмжээ авах;

3.3.Компанийн биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 11,647,200.00 м.кв талбай бүхий 7 ширхэг газар эзэмших эрхийг газрын мэдээллийн цахим системд бүртгүүлэх;

3.4.Компанийн санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй, “Очко” орчуулгын төвөөр 2018 онд хийлгэсэн орчуулгын төлбөр 950,000.00 (есөн зуун тавин

мянган) төгрөгийг олгох шийдвэр гаргасан буруутай этгээдээр 2025 оны 03 дугаар улиралд багтаан нөхөн төлүүлэх;

3.5. Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд төрийн ашиглах нийтлэг журам”-ын 3.6-д заасны дагуу автомашины тоо, автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6-д заасны дагуу автомашины тоо, автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6-д заасны дагуу автомашины тоо, төрлийг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар тогтоолгох;

3.6. Гүйцэтгэх захирлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг хүчингүй болгож, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчтэй хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон ажиллах;

3.7. Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахыг таслан зогсоох, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

4. Тогтоолын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 20 дугаар сарын 20-ны өдрийн
20 дугаар тогтоолын хавсралт



**“ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХХКД
ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/Д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга		Үнийн дүн (төгрөг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Үндсэн баримтын бүрдэл дутуу	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ	6,900,000.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ыгмөрдөж ажиллах.
		Тушаал шийдвэргүй	9,400,000.00	
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй шууд худалдан авсан бараа, ажил үйлчилгээ		50,218,770.00	Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах.
Нийт дүн		66,518,770 (жаран зургаан сая таван зуун арван найман мянга долоон зуун далан) төгрөг		